| 158 | Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны дээврийн засварын ажил | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 0 | 20.00 | 0 | - | Санхүүжилтийн эх үүсвэр тасарсан тул тухайн онд санхүүжүүлэх боломжгүй болж 2025 онд санхүүжүүлэхээр баталсан | 0 |
| 159 | Гурванбулаг сумын наадмын талбайн засварлах ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 50 | 125.0 | 65 | 52.0 | Гурванбулаг сумын наадмын талбайн засварлах ажлыг "Тэгш гурван учрал" ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. Баян-овоо сумын наадмын талбайн засварлах ажил төсвийн орлого тасарсантай холбоотойгоор төсөл арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлээгүй бөгөөд 2025 онд хэрэгжүүлэхээр төсөвт тусгасан. | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 160 | Баянлиг сумын цэнгэлдэхийн тохижилтын ажил | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 0 | 5.0 | 0 | - | Санхүүжилтийн эх үүсвэр тасарсан тул тухайн онд санхүүжүүлэх боломжгүй болж 2025 онд санхүүжүүлэхээр баталсан | 0 |
| 161 | Баян-Овоо сумын гудамж талбайн засварлах ажлыг хийж гүйцэтгэх | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 0 | 20.00 | 0 | - | Санхүүжилтийн эх үүсвэр тасарсан тул тухайн онд санхүүжүүлэх боломжгүй болж 2025 онд санхүүжүүлэхээр баталсан | 0 |
| 162 | Богд сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 20.00 | 20 | 100.0 | Богд сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг иргэн Б.Чулуунболд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. | 100 |
| 163 | Улсад төвлөрүүлэх дамжуулан зээлийн өр | Зээл төлөлт | Дүн | 2022 | 543 | 307.65 | 307.6463 | 307.65 | 307.65 | 100.0 | Улсын төсвийн дамжуулан зээлийн 2024 онд төлөх 307.646.300 төгрөгийн өрийг 100 хувь бүрэн төлж барагдуулсан. | 100 |
| 164 | Баянхонгор сумын 7 дугаар багийн гудамжны өнгө үзэмжийг сайжруулах. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100.00 | 50 | 95.00 | 43 | 45.2 | Баянхонгор сумын 7 дугаар багийн гудамжны өнгө үзэмжийг сайжруулах ажлын гүйцэтгэгчээр "Гэгээн шавь" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Энэ онд батлагдсан төсвийн дагуу 50 орчим айлын хашааг зосдож янзалсан. Тус ажил нь 2025 оны 2 дугаар улиралд бүрэн дуусна. | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 165 | Баянхонгор сумын 7 дугаар багийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100.00 | 100 | 15.00 | 15 | 100.0 | Баянхонгор сумын 7 дугаар багийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлэх ажлыг Тоонотхонгор ХХК бүрэн нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Санхүүжилтийг бүрэн олгосон. | 100 |
| 166 | Баянхонгор сумын 9 дүгээр багт улсын чанартай зам дагуу ногоон байгууламж байгуулах. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100.00 | 100 | 110.0 | 107.2 | 97.4 | Баянхонгор сумын 9 дүгээр багт улсын чанартай зам дагуу ногоон байгууламжийн ажлыг "Түйн голын төгөл" ХХК хийж гүйцэтгэн 2024 оны 06 дугаар сард ашиглалтад оруулсан. | 100 |
| 167 | Баянбулаг сумын гудамжны өнгө үзэмжийг сайжруулах. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100.00 | 100 | 20.00 | 20 | 100.0 | Баянбулаг сумын гудамжны өнгө үзэмжийг сайжруулах ажлыг "Баян тээх" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. | 100 |
| 168 | Баянхонгор аймаг дахь нисэх буудлын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100.00 | 100 | 20.00 | 20 | 100.0 | Тус ажлын хүрээнд хуучин барилгын гадна ханыг хусаж цэвэрлэх, гадна ханыг будах, ТП-ний гадна ханыг эмульсэн будгаар будах, 10ш гацуур тарих зэрэг ажлыг тус тус хийж гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 169 | Шаардлагатай сургууль, цэцэрлэгийн орчмын авто замыг стандартын тэмдэг тэмдэглэгээтэй болгох, камержуулалтыг сайжруулах. | Тоо | Тоо | 2022 | 3 | 8 | 0 | 82.74 | 82.7 | 100.0 | Тус ажлын хүрээнд тендэр сонгон шалгаруулалтыг зарлаж "Тод тунгалаг тэмдэг" ХХК шалгарч гэрээ байгуулсан ба автозамын термопластик будаг, хурд сааруулагч болон шаардлагатай бараа материалуудыг нийлүүлсэн. 1000мкв талбайд төв зам дагуу хэвтээ тэмдэг тэмдэглэгээ хийсэн. | 0 |
| 13.3.3.Эрчим хүчний алдагдлыг 2 хувиар бууруулна. | | | | | | | | | | | | |
| 170 | 6квт-10квт шилжүүлэхэд шаардлагатай трансформатор нийлүүлэх. | Гүйцэтгэлийн хувь | Тоо | 2022 | 0 | 100 | 100 | 152.7 | 152.6 | 100.0 | 6квт-10квт шилжүүлэхэд шаардлагатай трансформатор нийлүүлэх ажлыг "Ноён сайхан" ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 171 | 110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл хийх ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 15 | 100 | 100 | 7,312.7 | 7312.7 | 100.0 | Баянхонгор аймгийн 110/35/6 кВ-ын 12 МВА суурилагдсан чадалтай дэд станцын өргөтгөлийн ажлыг 110/35/10 кВ-ын 36 МВА суурилагдсан чадалтайгаар өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ Трейд" ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг 2022 онд эхлүүлж 2024 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. Тус ажлын хүрээнд 5CVG 2ш бүрэн суурилуулсан. Энэ онд хаалттай хуваарилах байгууламж, 10кВ-ын 16 МВА суурилагдсан чадалтай трансформаторыг бүрэн суурилуулах ажлууд тус тус хийгдсэн. | 100 |
| 172 | Жаргалант сумын төвд 0.4кв өргөтгөл хийх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 80.00 | 80 | 100.0 | Жаргалант сумын төвд 0.4кв өргөтгөлийн ажлыг "Ган утас мөнхжин" ХХК хийж гүйцэтгэн 2024 оны 07 дугаар сард ашиглалтад оруулсан. | 100 |
| 173 | Шинээр газар олгогдож буй 1200 айлыг цахилгаан эрчим хүчинд холбох ажлыг эхлүүлэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 30 | 10 | 400.0 | 0 | - | Шинээр газар олгогдож буй 1200 айлыг цахилгаан эрчим хүчинд холбох ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ трейд" ХХК гэрээ байгуулсан. Тус ажлыг 2025 оны 4 дүгээр сард эхлүүлнэ. | 33 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 174 | Өлзийт сумын төвийн 0.4 шугамын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 80 | 160.0 | 160 | 100.0 | Өлзийт сумын төвийн 0.4 шугамын өргөтгөлийн ажлыг "Алтан заяа ундарга" ХХК хийж гүйцэтгэсэн. Ажлын явц 80 хувьтай байна. | 80 |
| 175 | Шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 30 | 0 | 300.0 | 0 | - | Шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендэрийг зарлаад байна. | 0 |
| 176 | Баянхонгор сумын 2,6,9-р баг, Арван мянгатын ар, ойн зурвасаас хойш газар олгох газарт цахилгаан, гэрэлтүүлэг хийх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 150.0 | 149.9 | 100.0 | Баянхонгор сумын 2,6,9-р баг, Арван мянгатын ар, ойн зурвасаас хойш газар олгох газарт цахилгаан, гэрэлтүүлгийн ажлыг "Овоот сойвон" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. | 100 |
| 177 | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтцийн ажлыг хийх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 50 | 0 | 1,170.6 | 0 | - | Аймгийн төв баригдаж байгаа дулаан станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтцийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендэрийг Төрийн худалдан авах ажиллагааны газар зарлаад байна. | 0 |
| 14.Логистикийн гүйцэтгэлийн хувийг 56 хувиар сайжруулна. | | | | | | | | | | | | |
| 14.1.Ачаа тээврийн усгалыг 10 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14.1.1.Автозамын чанарын үзүүлэлтийг 8 хувиар сайжруулна. | | | | | | | | | | | | |
| 178 | Баянхонгор сумын Дунд захын гурван замын уулзвараас Доод захын гурван замын уулзвар хүртэл 0.5 км хатуу хучилттай авто замыг шинэчлэх. | Замын урт | Метр | 2022 | 0 | 500 | 100 | 227.00 | 227 | 100.0 | Тус ажлыг Баянхонгор сумын Засаг даргын хүсэлтийн дагуу тус сумд эрх шилжүүлж гүйцэтгэсэн бөгөөд тендэр сонгон шалгаруулалт зарлаж “Урагшлах үе” ХХК шалгарч 0.5 км авто зам шинэчлэлтийн ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн | 100 |
| 179 | Баянхонгор сумын Цагдаагийн газраас Арван мянгатын 4 замын уулзвар хүртэл 0.45 км хатуу хучилттай авто замыг шинэчлэх. | Замын урт | Метр | 2022 | 0 | 500 | 100 | 205.0 | 205 | 100.0 | Тус ажлыг Баянхонгор сумын Засаг даргын хүсэлтийн дагуу тус сумд эрх шилжүүлж гүйцэтгэж тендэр сонгон шалгаруулалт зарлаж “Урагшлах үе” ХХК шалгарч 0.45 км авто зам шинэчлэлтийн ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн | 90 |
| 180 | Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто зам тавих. | Замын урт | Метр | 2022 | 0 | 1700 | 0 | 760.0 | 0 | - | Тайлант онд тус ажлын зураг төсвийг “Гео урбан консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлж зураг төсвийг Зам, тээврийн хөгжлийн төвд зургийн экспертизээр оруулж тендэр сонгон шалгаруулалтыг 2 удаа зарлаж аж ахуй нэгж шалгараагүй болно. Тус ажлыг 2025 онд хийж гүйцэтгэхээр Баянхонгор аймгийн 2025 оны төсөвт давтан тусгасан болно. | 0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 181 | Баянхонгор сумын доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх. | Замын урт | Метр | 2022 | 1800 | 1000 | 650 | 40.00 | 40 | 100.0 | Тус ажлыг Баянхонгор сумын Засаг даргын хүсэлтийн дагуу тус сумд эрх шилжүүлж гүйцэтгэж, "Их богд зам" ХХК авто замын нөхөөсний ажлыг 650м2 талбайд хийж гүйцэтгэсэн. | 81 |
| 182 | Бууцагаан сумын төрийн байгууллагуудын дунд зам талбайн тохижилт хийх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 160.0 | 160 | 100.0 | Тус ажлыг Бууцагаан сумд эрх шилжүүлж, зам талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 183 | Галуут сумын "Сүмбэр" багийн хайрган хучилттай замын үлдэгдэл санхүүжилт | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 50 | 100 | 100 | 150.0 | 150 | 100.0 | Тендэр сонгон шалгаруулалт зарлаж "Талын нөмөр" ХХК шалгарч өмнө онд хийсэн авто замын ажлыг дахин нэг үе хучиж үер орж ирэх эрсдэлтэй хэсэгт 2 ширхэг төмөр хоолойг суурилуулж авто замын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100 |
| 184 | Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам тавих ажлыг эхлүүлэх 54.18км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/ | Замын урт | Метр | 2022 | 0 | 30 | 30 | 6,161.7 | 6161.7 | 100.0 | Тус ажлын эрх Баянхонгор аймагт шилжиж ирээгүй бөгөөд тендэр сонгон шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарлаж "Их богд зам" ХХК, "Их харгуйн зам" ХХК тус тус шалгарсан. Тайлант онд авто замын далангийн суурийн ажил мөн хоолойн ажлууд хийгдээд байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 185 | Түйн голын төмөр бетон гүүр тавих ажлыг эхлүүлэх. 64.75 у/м /Баянхонгор, Богд сум/ | Замын урт | Метр | 2022 | 0 | 50 | 100 | 1,625.0 | 1625 | 100.0 | Тус ажлын тендэр сонгон шалгаруулалтыг зарлаж "Их богд зам" ХХК шалгарч барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэж 2024 оны 09 дүгээр сард ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100 |
| 186 | Заг Байдрагийн голын эвдэрсэн хэсгийг засварлах. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 0 | 50.00 | 0 | - | Тус ажлыг Заг сумын Засаг даргын хүсэлтийн дагуу тус сумд эрх шилжүүлж гүйцэтгэж Заг сумын Засаг даргын Тамгын газраас тендэр сонгон шалгаруулалт зарлаж Буянт хөрс наран ХХК шалгарсан боловч тус ажлыг хийж гүйцэтгээгүй. | 0 |
| 187 | Баянхонгор сумын Арван мянгатын дөрвөн замын уулзвараас Хонгор хотхон хүртэлх 0.7 км явган зам шинээр тавих. | Замын урт | Метр | 2022 | 0 | 700 | 700 | 145.0 | 119.4 | 82.3 | Тус ажлын тендэр сонгон шалгаруулалт зарлаж “Буян арвижих од” ХХК шалгарч гэрээ байгуулж 2024 оны 05 дугаар сард явган замын угсралтын ажлыг эхлүүлж 2024 оны 06 дугаар сарын 11-нд улсын комисс ажиллаж 0.7 км явган замын ажлыг ашиглалтад хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 188 | Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам тавих ажлыг эхлүүлэх. 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/ | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 80 | 80 | 3,380.0 | 2566.5 | 75.9 | “Түм дэлгэрэх” ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 2022/53 дугаартай 7,995,198,327 төгрөгийн гэрээ байгуулж тус ажлыг гүйцэтгүүлсэн. Авто зам угсралтын ажил 100% бүрэн дууссан ба Зам, тээврийн хөгжлийн төвд техник ашиглалтын түвшин тогтоох хүсэлт хүргүүлсэн боловч тус шинжилгээний ажлыг хүйтний улиралд ажиллуулах боломжгүй тул улсын комисс хараахан ажиллаагүй байна. | 100 |
| 189 | Баянхонгор сумын 6 дугаар багийн үерт идэгдсэн замын засварын ажил | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 32.5 | 32.5 | 100.0 | Баянхонгор сумын 6 дугаар багийн үерт идэгдсэн замын засварын ажлыг Талын нөмөр ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Санхүүжилтийг бүрэн олгосон. | |
| 190 | Эрдэнэцогт сумын Ямаан усны давааны үерт идэгдсэн замын засварын ажил | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 40.00 | 40 | 100.0 | Эрдэнэцогт сумын Ямаан усны давааны үерт идэгдсэн замын засварын ажлыг Марал гүн ХХК хийж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Санхүүжилтийг бүрэн олгосон. | |
| 191 | Зам арчилгаанд шаардлагатай давс худалдан авах. | Давсны хэмжээ | Тонн | 2022 | 6 | 60 | 50.8 | 40.00 | 40 | 100.0 | Тус ажлыг Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-т эрх шилжүүлж гүйцэтгэж 2025 онд авто замын халтиргаа гулгаа, зам арчилгаанд ашиглах 50.8тн давс нөөцөлсөн. | 100 |
| 15.Хүнсний аюулгүй байдлыг 7.6 хувиар сайжруулна. | | | | | | | | | | | | |
| 15.1.Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг орон нутагт 0.5 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 15.1.1.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний улирлын хэлбэлзлийг 1 бууруулна. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 192 | Иргэдийн оролцоотой хүлэмжийн аж ахуй байгуулах. | Хүлэмжийн тоо, Хүлэмжийн аж ахуй эрхэлж байгаа хүний тоо | Тоо | 2022 | 0 | 120 | 100 | 20.00 | 20 | 100.0 | Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхэд иргэн аж ахуй нэгжүүдийн оролцоог хангах зорилгоор мэдээлэл өгч Нарлаг хүлэмж ХХК-тай холбож өгснөөр 21 иргэн аж ахуй нэгжүүд өөрсдийн 37,8 сая төгрөгийн хөрөнгөөр 4*8 хэмжээтэй 21 хүлэмжийг лизингээр зээлээр худалдан авч ашиглаж ирсэн. Мөн 2024 онд Шинэ хөдөө төслийн санхүүжилтээр 4*8 хэмжээтэй 20, 4*10 хэмжээтэй 10 хүлэмж нийлүүлэгдэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд 10 хүлэмжийн дэмжлэг үзүүлэн хүлэмжийн талбайн хэмжээг өмнө оноос 1712 м2 талбайгаар нэмэгдүүллээ. Нийт 160 гаруй иргэн, аж ахуйн нэгж хүлэмжийн аж ахуй эрхэлж байна. Цаашид 2000 м2 талбай бүхий 3 улирлын хүлэмжийн цогцолбор нэмж байгуулагдахаар барилгын ажил хийгдэж байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 193 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх. | Нөөц бүрдүүлэлт | Тонн | 2022 | 180 | 200 | 314 | 60.00 | 0 | - | 2024 оны хувьд орон нутгийн төсвөөс махны нөөц бүрдүүлэхээр баталсан хөрөнгийг өвөлжилтийн нөхцөл хүндэрсэнтэй холбоотойгоор өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулж хувийн ААН болох "Дэвжих өлзий хишиг" ХХК нь нөөцөд 10 тн үхэр, 4 тн ямаа, Баянхонгор констракшны "Мах март" ХХК нь нөөцөд 300 тн махыг тус тус бэлтгэж иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн. Худалдаанд ямаа-6000, хонь-10000, үхэр-12500 төгрөгийн ханштай байгааг зах зээлийн ханштай харьцуулахад кг тутам 3000-5000 төгрөгийн хямд борлуулагдсан. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 194 | Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ, Хүнсний хувьсгал үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн аж ахуй нэгж, байгууллагад зориулсан практик сургалт зохион байгуулах. | Зохион байгуулсан сургалт | Тоо | 2022 | 0 | 2 | 2 | 10.00 | 10 | 100.0 | Хүлэмжийн аж ахуй эрхэлэгчид болон төмс, хүнсний ногоо тариалагчдад зориулсан танхимын болон практик сургалтыг үе шаттай зохион байгуулж Эхийн голын тариалан эрхлэгчдэд зориулсан сургалтыг 4 дүгээр сард, 100 хүлэмжийн аж ахуйн цогцолборын ногоочдод зориулсан сургалтыг 5 дугаар сард тус тус зохион байгуулж 68 тариаланч хамруулсан. Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ, Хүнсний хувьсгал үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан практик сургалтыг зохион байгуулахаар аймгийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10,0 сая төгрөгийг төсөвлөн МОРА ЖИ ЭЙ ГРУПП ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. 09 дүгээр сард төлөвлөснөөр сумдын газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг оролцуулсан сургалтыг 09 дүгээр сарын 05-06 ны хооронд амжилттай зохион байгууллаа. | 100 |
| 15.1.2.Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг 5 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 195 | "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах. | Зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо | Тоо | 2022 | 1 | 1 | 1 | 30.00 | 30 | 100.0 | "Намрын ногоон өдрүүд-Шилмэл мал 2024" үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 20-22 ны өдрүүдэд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 13 сумын 110 иргэн, аж ахуйн нэгж оролцож 100 орчим сая төгрөгийн борлуулалт хийсэн бол Шилмэл малын үзэсгэлэнд 7 сумын 36 толгой мал оролцлоо. Онцлог шинэ бүтээгдэхүүнээр Их халбагант ХХК-ийн Иддэг сүү, ХХААГ-ын Зохиомол хээлтүүлэг, Сондор брэндийн Гар урлал шалгарсан. Импортыг орлох, экспорт руу чиглэсэн бараа бүтээгдэхүүнээр Урт настын эх ХХК-ийн Чонон хармаг, Энгүүмэл баян ХХК-ийн Гутал, Бөмбөгөр сумын иргэн Т.Эрдмаагийн Сүлжмэл эдлэл шалгарсан. Шилдэг үйлдвэрлэл эрхлэгчээр Баянхонгор сумын иргэн Д.Лхагваа, Р.Буян нарын Сийлбэр, Кодаш ХХК-ийн Ариусал саван шалгарав. Шилдэг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээр Ерөөлтэй Элүл ХХК-ийн Жимс жимсгэнэ, Баянлиг сумын иргэн С.Чулууны Хүнсний ногоо, Очир бумбатын хишиг ХХК-ийн Хүнсний ногоо шалгарлаа. Шилдэг хоршоо, шилдэг үйлдвэрлэл эрхлэгчээр "Өгөөж баян өлзийт" хоршоо Ноолууран бүтээгдэхүүнээр, "Баялаг ундрам" хоршоо Цагаан идээгээр, "Таван | 100 |
| 196 | Ингэний сүүний үйлдвэрийн ашиглалтын өмнөх захиргааны зардлыг санхүүжүүлэх, хяналт | Гүйцэтгэл | Тонн | 2022 | 0 | 100 | 100 | 17.00 | 17 | 100.0 | 2023 оны цалингийн үлдэгдэл өр байсныг шилжүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 197 | Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих. | Үзүүлсэн дэмжлэгийн тоо | Тоо | 2022 | 0 | 1 | 1 | 50.00 | 50 | 100.0 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/83 дугаар захирамжаар Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр 50.0 сая төгрөгийг шилжүүлсэн. Тус төв камержуулалт, хүлэмжийн аж ахуй, цахилгааны засварын ажил, ажилчдын хувцас зэрэг ажил үйлчилгээнд зарцуулан ажилласан. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 198 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 30 | 100 | 100 | 2,000.0 | 2000 | 100.0 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах Нийт төсөвт өртөг 13,755 тэрбум төгрөг.<br>- Багц 1 – Ингэний сүүний үйлдвэрлэлийн барилгын ажлыг Базардарь ХХК шалгарч гүйцэтгэхээр 4,853 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Барилгын ажлыг барьж, тоног төхөөрөмжийг суурилуулж дууссан. Авах санхүүжилтээс 3,848 тэрбум төгрөгийг авсан. 1,005 тэрбум төгрөгийг 2025 оны төсөвт суулган санхүүжүүлэхээр байна.<br>- Багц 2 – Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажил буюу өвлийн хүлэмжийн барилгын ажилд Бэнжцэс ХХК шалгарч 2,585 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Нийт 3 хүлэмж барьж ашиглалтад оруулсан.<br>- Багц 3 – Мах, ногооны 1000 тн-ы зоорийн барилга, бойны газрын барилгын ажилд Сань-Өндөр ХХК шалгарч 4,869 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж барилгын ажлыг бүрэн дуусган ашиглалтад оруулахад бэлэн болж 3,074 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 794,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.<br>Ингэний сүүний үйлдвэр болон өвлийн хүлэмж, мах ногооны 1000 тн-ы зоорийг хувьчлах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>- Багц 4 – Шинэ суурьшлын бусийн | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 199 | Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн хэрэгжүүлэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 30 | 100 | 90 | 5,930.60 | 5013.8 | 84.5 | Хөдөө аж ахуйн кластер - Малын тэжээл дэд төсөл: Нийт төсөвт өртөг 10,990 тэрбум төгрөг.<br>- Багц 1 – Хөдөө аж ахуйн кластерийн барилга, байгууламжийн ажлын тендэрт “Татах хүч” ХХК шалгаран 3,315 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэж 2,108 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан, 1,207 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Ажлын явц 63 хувьтай. Өлзийт сумд байрлах кластер төслийн талбайд Тэжээлийн үйлдвэр, ажилчдын байр, агуулах, гражийн барилга зэрэг ажлууд хийгдэж байна.<br>- Багц 2 – Гүн, өрмийн худаг, ногоон тэжээлийн газрын хашаажуулалтын ажилд Номгоны андууд ХХК шалгаран 373,9 сая төгрөгийн гэрээ байгуулан ажлыг бүрэн хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үлдэгдэл санхүүжилт байхгүй. Бууцагаанд сумд 70га талбай, Хүрээмарал сумд 20га талбай, Баацагаан сумд 50га талбай, Баянлиг сумд 50га талбай, Өлзийт сумд 50га нийт 240 га талбайг хашаажуулж Өлзийт, Хүрээмарал, Бууцагаан сумдад нийт 3 ширхэг гүн өрмийн худаг гаргаж ашиглалтад оруулсан.<br>- Багц 3 – Тариалангийн талбайн цахилгаан станц, дэд станцын ажлыг Гарьд системс ХХК 191,3 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 200 | Төв хангайн бүсийн ахуйн үйлчилгээний ажилчдын ур чадварын тэмцээн зохион байгуулах, ахуйн үйлчилгээ болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг туршлага судлуулах. | Хүн | Тоо | 2022 | 0 | 45 | 120 | 20.00 | 20 | 100.0 | Төв, хангай, говийн бүсийн Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын ахуйн үйлчилгээний ажилчдын ур чадварын тэмцээн Баянхонгор аймагт 2024 оны 04 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдлаа. Тэмцээний зорилго нь ахуйн үйлчилгээний салбарын орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг олон нийтэд сурталчлах, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжил, мэргэшлийн ур чадвар, бүтээлч хандлагыг дээшлүүлэх зорилготой юм. Арга хэмжээг 2024 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээнд тусган санхүүжүүлсэн ба дээрх аймгуудын төлөөлөл 120 орчим оролцогч, дагалдах албаны хүмүүс, дасгалжуулагчдын хамтаар ирж оролцлоо. Тэмцээн 15 төрөлд 350 гаруй бүтээлээ уралдуулан шилдгүүдээ тодруулсан. | 100 |
| 16.Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 22.5 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 16.1.Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн тоог 2 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 16.1.1.Малын халдварт өвчний гаралтыг 80 хувиар бууруулна. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 201 | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах. | Малын тоо /сая/ | Тоо | 2022 | 3 | 3 | 4.1 | 814.10 | 814.1 | 100.0 | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэн дархлаажуулалтад 1,6 сая толгой мал хамруулсан. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Үхэр-171395, Гахай- 175 нийт-171570 мал, амьтан, “Хонины цэцэг” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 12 сумын 2356 өрхийн 694001 бог малыг, “Бог малын мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 4 сумын 560 өрхийн 447230 бог малыг хамруулан 99,3%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Мөн шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэн арга хэмжээнд арга хэмжээ буюу Угаалга-1.0 сая, Туулга-1.0 сая, боловсруулалт-432.7 мянга, гуурын боловсруулалт-22,9 мянга буюу нийт 2.5 сая толгой малыг хамруулж 92.7%-тай хэрэгжүүлсэн. Өөрөөр хэлбэл мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 4,1 сая толгой мал хамруулж халдварт өвчний гаралт өмнөх оныхоос 56%-р буурсан байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 202 | Хөдөө аж ахуйн салбарын дутагдалтай мэргэжилтэн бэлтгэх. | Суралцагч | Тоо | 2022 | 19 | 19 | 10 | 40.00 | 25.5 | 63.7 | Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай мэргэжлээр сурч буй оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж тайлант онд 3 оюутан төгсөж ажлын байран дээр ажиллаж байна. Мөн 2 оюутан жилийн чөлөө авч, 5 оюутан хангалтгүй суралцсан тул төлбөрийг нэхэмжлэхээр болж тэтгэлгийг түдгэлзүүлсэн. 2024-2025 оны хичээлийн жилд үлдсэн 10 оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэхээр 22.4 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсвөөс олгосон. Мөн аймгийн Хөдөө аж ахуйн газрын Б.Мөнх-Эрдэнэ, Б.Цэрмаа, А.Цэдэвсүрэн нарын 3 мэргэжилтэн зохиомол хээлтүүлгийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдан мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн тул сургалтын төлбөрт 3.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Нийт ажиллах хүний нөөцийн 60%-ийг бүрдүүлээд байна. | 53 |
| 16.1.2.Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг 10 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 203 | Малчдын бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулах. | Зөвлөгөөнд оролцсон малчид | Тоо | 2022 | 0 | 500 | 273 | 5.00 | 0 | - | Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, нийлүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотод 120, Өвөрхангай аймагт 88, Архангай аймагт 65, нийт 273 малчин, хоршооны төлөөллийг бүсчилсэн байдлаар уулзалт, сургалтад хамруулаа. | 55 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 204 | Баталгаажсан үүлдэр омгийн малд шилэн сонголт хийх | Малын тоо | Тоо | 2022 | 12000 | 13500 | 14249 | 19.00 | 19 | 100.0 | Баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг, ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, малын генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох зорилгоор улсын төсвийн 26.4 сая төгрөг, аймгийн төсвийн 19.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн. Хавар, намрын технологит хугацаанд Залаажинст-Эдрэн үүлдэр, Бөмбөгөрийн улаан омгийн 7645 үржлийн ямаа, Ламын гэгээний улаан үүлдрийн 620 тэмээ, Байдраг үүлдрийн 1996 хонь, Баянбулаг омгийн 1482 хонь, нутгийн 2506 сарлаг бүгд 14249 толгой малыг үзлэг ангилалтад хамруулж, ашиг шимийн түвшинг тогтоосон. Тухайн үүлдэр омгийн мал үүлдэр, омгоор батлагдах үеийн амьдын жингээс Залаажинст-Эдрэн үүлдрийн болон Бөмбөгөрийн улаан омгийн ямаа нас хүйс тус бүрдээ 1,1-7 кг-аар, Баянбулаг омгийн хонь нас, хүйс тус бүрдээ 1,2-15,5 кг-аар, нутгийн монгол сарлаг 20 кг-аар, Ламын гэгээний улаан үүлдрийн тэмээ нас хүйс тус бүрдээ 56-75 кг-аар тус тус нэмэгдсэн дүнтэй байна. Үзлэг ангилалтад хамрагдсан малаас шилэн сонголт хийж, бусад өрхийн малын чанарыг сайжруулах үржлийн мал бойжуулах зорилгоор цөм сүргийн 10526 хээлтэгч, хээлтүүлэгч малыг сонгон үржлийн цөм сүрэг бүрдүүлсэн. Үүнд: | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 205 | Бод малд зохиомол хээлтүүлэг хийх. | Гарсан төлийн тоо | Тоо | 2022 | 0 | 82 | 53 | 19.80 | 19.8 | 100.0 | 2023 онд 82 үхэрт зохиомол хээлтүүлэг хийж 2024 оны хавар 53 төл хүлээн авч 65%-ийн үр дүнтэй хэрэгжүүлсэн. Зохиомол хээлтүүлэг шалгах багаж тоног төхөөрөмж байхгүйгээс технологийн алдаа гарч үр дүн буурсан. Харин 2024 онд бод малд зохиомол хээлтүүлэг хийхээр аймгийн төсвөөс 19,0 сая төгрөгийг баталсан. Энэ дагуу Бөмбөгөр, Баацагаан, Баянхонгор сумын 6 өрхийн 100 үнээнд, мөн Жинст сум ОНХС-ын 10 сая төгрөгөөр 50 үнээнд тус тус зохиомол хээлтүүлэг хийсэн. Намрын хээл шалгалтаар 80%-ийн үр дүнтэй байна. | 65 |
| 206 | Шинэжинст сумын Залаажинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулах. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 20.00 | 20 | 100.0 | Залаажинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулах судалгааны ажлыг Залаа зөвлөл ТББ гүйцэтгэж 20,0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан. Судалгаагаар Залаажинстийн цагаан ямаан сүргийн малчид тухайн жилийн ямааны зарлагаа бойжуулсан төлөөрөө нөхөн үйлдвэрлэж чадахгүй байна. Үүний улмаас ямаан сүргийн тоо толгой хорогдож, малчид хэрэглээгээ хангахын тулд гадны аймаг, сумаас ямаа худалдан авч өсгөж байгаа нь сүргийн доторх өөр зүсний ямааны тоо толгойг өсгөхөд нөлөөлж ашиг, шимийн үзүүлэлт буурах хандлагатай байгааг тодорхойлсон байна. Холбогдох судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага болон сумдад хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 207 | Баянцагаан сумын цөм сүргийг бүрдүүлэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 10 | 0 | 30.00 | 0 | - | Холбогдох сумдад техникийн тодорхойлолтыг ирүүлэх чиглэл өгсөн боловч ирүүлээгүй тул хэрэгжихгүй болсон. | 0 |
| 208 | Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "МАА-н салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж" төслийн тоног төхөөрөмжөөр хангах. | Тоног төхөөрөмжийн тоо | Тоо | 2022 | 0 | 30 | 460 | 1,000.0 | 1000 | 100.0 | Тус ажлыг гүйцэтгэгч Бэст Агро интернэйшнл ХХК нь улсын төсвийн 800,0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэж 4 төрлийн 460 ширхэг тоног төхөөрөмж (Цахилгаан хадуур, Малын байршил тогтоогч, олон үйлдэлт трактор, Сүүний машин) хүлээлгэн өгснийг аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/66 захирамжийн дагуу сумдад хуваарилсан. | 100 |
| 209 | Мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарын тоног төхөөрөмжөөр хангах. | Тоног төхөөрөмжийн тоо | Тоо | 2022 | 0 | 50 | 698 | 2,500.0 | 2500 | 100.0 | Улсын төсвийн 2,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөх бүрдний ХХК гүйцэтгэн 10 төрлийн 698 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлснийг аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/66 захирамжийн дагуу сумдад хуваарилсан. | 100 |
| 17. Гэмт хэрэг, зөрчлийг 3.3 хувиар бууруулна | | | | | | | | | | | | |
| 17.1.Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг 0.5 хувиар нэмэгдүүлнэ | | | | | | | | | | | | |
| 17.1.1.Гэмт хэргийн хувийг 0.2 хувиар бууруулна | | | | | | | | | | | | |
| 210 | Террозимтэй тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тоо | 2022 | 1 | 2 | 9 | 3 | 3 | 100.0 | Террозимтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд 9 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хэрэгжсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 211 | Эрдэнэцогт сумын цагдаагийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 50% | 15 | 15 | 100.0 | Эрдэнэцогт сумын цагдаагийн хэсгийн барилгын урсгал засварын ажлыг гүйцэтгэхээр иргэн Д.Батсайхан, Г.Дондог нартай гэрээ байгуулан, гүйцэтгэл 50 хувьтай байна. | 50 |
| 212 | Гурванбулаг, Жаргалант суманд байрлах сум дундын цагдаагийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 50% | 20 | 20 | 100.0 | Гурванбулаг, Жаргалант сумын цагдаагийн хэсгийн байранд урсгал засварын ажлын гүйцэтгэгчээр “Буянт зэндмэнэ өргөө” ХХК шалгарч гэрээ байгуулан, гүйцэтгэл 50 хувьтай байна. | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 213 | Хууль бус ан агнуур болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт зохион байгуулах | Хууль бус ан агнуур болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт зохион байгуулах | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 4.0 | 4 | 100.0 | Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/473 дугаар захирамжийн дагуу хууль бус ан агнуур болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн хяналт шалгалтыг Баянхонгор, Өлзийт, Бөмбөгөр, Баян-Овоо, Баянбулаг, Гурванбулаг, Галуут, Жаргалант, Эрдэнэцогт, Заг, Бууцагаан, Хүрээмарал сумдад 2024 оны 08-10 дугаар сарын хооронд зохион байгуулсан.<br>Аймгийн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөдөө сумдад хөдөлгөөнт эргүүлээр ажиллах албан хаагчдын шатахуун, томилолтын зардалд 3.0 сая төгрөг, Зооноз өвчин судлалын төвийн ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Мөн тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааны зардлаас хяналт шалгалтын ажилд 17.6 сая төгрөгийг зарцуулсан.<br>Хяналт шалгалтын ажлын үр дүнд хууль бусаар амьтан агнах, барихтай холбоотой 53 зөрчил илэрүүлж 11,400,000 төгрөгийн торгууль, 85,952,000 төгрөгийн нөхөн төлбөрийг ногдуулсан. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 214 | Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарын барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэх | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 100 | 10.00 | 10 | 100.0 | Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарын барилгын дотор засврыг Б,М,Б,Ж,Б ХХК бүрэн хийж дууссан | 100 |
| 215 | Баянхонгор сумын нийтийн орон сууцнуудын орц, гарцыг камержуулах, тохижилт, гэрэлтүүлгийг хийх | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 60 | 260.0 | 0 | - | Баянхонгор сумын 6 дугаар багт 14 ширхэг шонтой гэрэлтүүлэг, 3 дугаар багт 3 ширхэг гэрэлтүүлгийн толгой, 8 ширхэг шонтой гэрэлтүүлэг, 5 дугаар багт 30 гэрэлтүүлгийн толгой, 60 ширхэг шонтой гэрэлтүүлэг, 8 дугаар багт 16 гэрэлтүүлэг, 10 дугаар багт 17 гэрэлтүүлэг тус тус хийсэн. Мөн хөдөлгөөнт камер 2 ш, чиглэл камер 45 ширхгийг байрлуулж ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна. | 60 |
| 216 | Шуурхай удирдлагын төвийг байгуулах. | гүйцэтгэл | хувь | 2022 | 10 | 50 | 30% | 200 | 200 | 100.0 | “Мэдээлэл шуурхай удирдлагын төв”-ийг байгуулахаар орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөгийг батлуулан, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч ашиглалтад орууллаа. Гэмт хэргийн илрүүлэлт 21.1 хувьтай байгаа нь өмнөх мөн үеэс 12.2 пунктээр буурсан байна. | 50 |
| 17.2.Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэл бүхий иргэдийн тоог 1 хувиар бууруулна | | | | | | | | | | | | |
| 17.2.1.Иргэдийн мэдээллээр ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог 1 хувиар нэмэгдүүлнэ | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 217 | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А-297,360 дугаар тушаалаар батлагдсан Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишгийг олон нийтэд сурталчлан таниулах | Сурталчилгааны хувь | Хувь | 2022 | 0 | 20 | 100% | 3 | 3 | 100.0 | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А-297,360 дугаар тушаалаар батлагдсан Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишгийг олон нийтэд сурталчлах чиглэлээр гарын авлага 3600, плакат 500 ширхгийг бэлтгэн хэвлүүлж, 15 сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгч, сурталчлан ажиллах талаар чиглэл өгч ажилласнаар гэмт хэрэг 326 бүртгэгдэж, 1 дахин, зөрчил 14484 бүртгэгдэж 4.1 хувиар тус тус өссөн байна. | 100 |
| 218 | Гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг төлбөртэй авах арга хэмжээг зохион байгуулах. | Төлбөртэй авсан мэдээлэл | Тоо | 2022 | 0 | 2 | 0 | 2 | 0 | - | Гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг төлбөртэй авах арга хэмжээг зохион байгуулж гарын авлагыг 3600 иргэнд түгээж ажилласан. Иргэдээс төлбөртэй авах мэдээлэл ирүүлээгүй тул төсвийг зарцуулаагүй болно. | 100 |
| 18.Хүний эрхийн баталгаа хангагдсан 80 орны нэг болно. | | | | | | | | | | | | |
| 18.1.Жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг сайжруулна | | | | | | | | | | | | |
| 18.1.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийн хэрэгжилтийг 40 хувьд хүргэнэ | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 219 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратегийг хэрэгжүүлэх /2022-2026 оны нэгдүгээр шатны/ арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний биелэлт | Хувь | 2022 | 0 | 40 | 75 | 20 | 17.1 | 85.5 | “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг 2023-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 80 ажил, арга хэмжээ тусган батлуулж, стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулж байна. Аймгийн Жендэрийн салбар хороо, Хууль эрх зүйн хэлтэс хамтран “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2023-2026 он/"-ний хэрэгжилтэд үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. "Гэр бүл ба жендэр" сургалт, нөлөөллийн арга хэмжээг аймгийн Дугуйн холбоотой хамтран зохион байгуулж, тус холбооны гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, дугуйн аялал зохион байгуулан жендэр, гэр бүл төлөвлөлт, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгосон. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар | 100 |

| |
|---|
| 18.2.Хүний эрхийн зөрчлийг 2 хувиар бууруулна. |
| 18.2.1.Хүний эрхийн талаар ойлголт мэдлэгийг дээшлүүлнэ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 220 | Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | Хэрэгжилт | Хувь | 2022 | 80 | 90 | 55 | 2 | 1.7 | 85.0 | Засгийн газрын 2023 оны 357 дугаар тогтоол “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 2024 оны А/13 дугаар захирамжаар арга хэмжээний төлөвлөгөөг баталж, орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөгийг шийдвэрлэн, биелэлт 55 хувьтай байна. Төлөвлөгөөнд тусгасан ажил арга хэмжээг зохион байгуулж, 15 сумын төрийн албан хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 2716 сурагчдад хүний эрхийн сургалт, мэдээллийг зохион байгуулж, хүний эрхийн мэдлэг ойлголтыг | 61 |
| 221 | Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд өргөтгөл, засвар хийх. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 100 | 70 | 243.0 | 0 | - | Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны орчин, нөхцөлийг сайжруулах, стандартад нийцүүлэх чиглэлээр 2023-2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 295.0 сая төгрөгийг шийдвэрлэж, гүйцэтгэгчээр “Буян-Арвижих-Од” ХХК шалгарч, өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна. | 70 |
| 222 | Наркологийн эмнэлэг барих. | Гүйцэтгэл | Хувь | 2022 | 0 | 80 | 0 | 2,314.1 | 0 | - | Баруун бүсийн Албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилгын нийт төсөвт өртөг 7.7 тэрбум төгрөгөөр батлагдаж, Эрүүл мэндийн яамны 2024 оны төсөвт 2.3 тэрбум төгрөг тусгагдаж, тендэр сонгон шалгаруулалтыг зарлаж "Итгэл тайж" ХХК шалгарч, гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. | 0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19.Авлигын үзүүлэлтээр 10 байр урагшилна | | | | | | | | | | | | |
| 19.1.Авлигын үл тэвчих соёл, хандлагыг 5 хувиар нэмэгдүүлнэ | | | | | | | | | | | | |
| 19.1.1.Шударга байдлын үнэлгээг 5 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |
